



ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА -2024/256 /НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ЭРДЭНЭ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ТӨСВИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он

Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер: О.Амаржаргал

Утас: 70273463. Цахим хаяг: amarjargal@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Голден пейж Аудит" ХХК Гүйцэтгэх захирал: С.Оюунгэрэл

Утас: 99170900 Цахим хаяг: info@goldenpageaudit.mn



Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.25 № 01/89
танай _____-ны № _____-т

ТӨВ АЙМГИЙН ЭРДЭНЭ СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Л.ХОСБАЯР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Эрдэнэ сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Эрдэнэ сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолоор хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх болсноор жилийн эцэст зарцуулагдаагүй мөнгөн хөрөнгийг дараагийн жилд зарцуулахаар заасантай холбоотой мөнгөн хөрөнгийн данс 155,286.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

019020108



Бусад асуудлын хэсэг

Төв аймгийн Боловсрол шинжлэх ухааны газрын даргаар батлуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 12 зорилтын хүрээнд 34 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 86,52 хувийн гүйцэтгэлтэй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ



АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....
4. Аудитын тайлан

 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>123,592,061.93</u>	<u>226,010,088.90</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	59,551,989.00	155,286,145.97
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	59,551,989.00	155,286,145.97
3121	Төгрөг	59,551,989.00	155,286,145.97
31211	Төрийн сангийн харилцах	59,551,989.00	155,286,145.97
33	АВЛАГА	3,644,346.00	142,066.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	3,644,346.00	142,066.00
35	БАРАА МАТЕРИАЛ	60,395,726.93	70,581,876.93
351	Түүхий эд материал	9,548,400.00	9,548,400.00
35110	Тусгай зориулалттай материал	9,548,400.00	9,548,400.00
354	Хангамжийн материал	37,957,326.93	46,793,476.93
35420	Аж ахуйн материал	16,280,000.00	20,060,000.00
35460	Хүнсний материал	3,943,850.00	00.00
35470	Бусад хангамжийн материал	17,733,476.93	26,733,476.93
35600	Мал амьтад	12,890,000.00	14,240,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>4,534,408,141.01</u>	<u>4,194,903,292.92</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,534,408,141.01	4,194,903,292.92
391	Газар	00.00	00.00
392	Биет хөрөнгө	4,461,758,641.01	4,122,253,792.92
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,787,048,520.02	5,787,048,520.02
39202	Хуримтлагдсан элэгдэл	-1,745,697,368.94	-2,129,762,346.71
39203	Авто-тээврийн хэрэгсэл	41,744,198.70	41,744,198.70
39204	Хуримтлагдсан элэгдэл	-35,843,865.40	-40,977,198.76
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	241,710,738.39	292,698,468.39
39206	Хуримтлагдсан элэгдэл	-44,564,128.23	-42,998,987.49
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	189,402,502.24	187,705,838.24
39208	Хуримтлагдсан элэгдэл	-17,085,774.47	-14,643,312.11
39214	Бусад үндсэн хөрөнгө	40,161,951.27	44,975,151.91
39215	Хуримтлагдсан элэгдэл	-24,930,445.03	-26,600,237.43
39217	Ном	29,812,312.46	23,063,698.16
393	Биет бус хөрөнгө	72,649,500.00	72,649,500.00
39301	Програм хангамж	1,212,500.00	1,212,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-275,000.00	-275,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	71,712,000.00	71,712,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>4,658,000,202.94</u>	<u>4,420,913,381.82</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>4,658,000,202.94</u>	<u>4,420,913,381.82</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	4,658,000,202.94	4,420,913,381.82



511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,291,187,505.12	1,291,187,505.12
51101	Өмч: - төрийн	1,291,187,505.12	1,291,187,505.12
512	Хуримтлагдсан үр дүн	2,806,601,218.55	2,569,514,397.43
51210	Өмнөх үеийн үр дүн	2,806,601,218.55	2,806,601,218.55
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-237,086,821.12
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	560,211,479.27	560,211,479.27
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,658,000,202.94	4,420,913,381.82

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	6,647,344,079.06	1,941,472,648.92
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,133,403,879.06	61,848,948.00
120	Нийтлэг татварын бус орлого	4,962,234,679.06	61,848,948.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,959,188,079.06	57,178,000.00
120009	Бусад орлого	3,046,600.00	4,670,948.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	1,171,169,200.00	00.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	1,171,169,200.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	513,940,200.00	1,879,623,700.92
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	439,160,300.00	1,460,043,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	439,160,300.00	1,460,043,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	74,779,900.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	74,779,900.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	419,579,800.92
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	419,579,800.92
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,022,002,480.12	2,167,040,855.74
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,022,002,480.12	2,167,040,855.74
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,874,838,565.12	2,078,016,085.86
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	823,294,815.00	937,822,419.73
210101	Үндсэн цалин	617,974,577.00	674,394,430.86
210102	Нэмэгдэл	185,606,652.00	221,248,160.99
210104	Урамшуулал	19,713,586.00	42,179,827.88
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	97,635,923.00	115,326,020.30
210201	Тэтгэврийн даатгал	67,791,709.81	80,119,558.70
210202	Тэтгэмжийн даатгал	7,975,488.01	9,419,071.19
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,266,150.43	7,452,516.81
210204	Ажилгүйдлийн даатгал	1,415,528.41	1,655,607.41



210205	Эрүүл мэндийн даатгал	14,187,046.34	16,679,266.19
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	384,106,360.00	414,568,481.04
210301	Гэрэл, цахилгаан	20,680,887.00	24,975,681.04
210302	Түлш, халаалт	331,840,473.00	368,710,300.00
210303	Цэвэр, бохир ус	31,585,000.00	20,882,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	147,163,915.00	89,024,769.88
2132	Бусад урсгал шилжүүлэг	146,268,200.00	89,013,450.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	71,488,300.00	69,400,850.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	74,779,900.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	19,612,600.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	895,715.00	11,319.88
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	895,715.00	11,319.88
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>4,625,341,598.94</u>	<u>-225,568,206.82</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	5,909,000.00	11,518,614.30
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	5,909,000.00	6,838,614.30
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.00	4,680,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-5,909,000.00	-11,518,614.30
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>4,619,432,598.94</u>	<u>-237,086,821.12</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,688,156,000.00</u>	<u>1,884,294,648.92</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,174,215,800.00	424,250,748.92
120	Нийтлэг татварын бус орлого	3,046,600.00	4,670,948.00
120009	Бусад орлого	3,046,600.00	4,670,948.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	1,171,169,200.00	419,579,800.92
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	1,171,169,200.00	419,579,800.92
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	513,940,200.00	1,460,043,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	74,779,900.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	74,779,900.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	439,160,300.00	1,460,043,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	439,160,300.00	1,460,043,900.00



2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,587,218,011.00</u>	<u>1,744,145,501.95</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,587,218,011.00	1,744,145,501.95
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,440,054,096.00	1,655,842,782.07
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	788,721,748.00	934,320,139.73
210101	Үндсэн цалин	583,401,510.00	670,892,150.86
210102	Нэмэгдэл	185,606,652.00	221,248,160.99
210104	Урамшуулал	19,713,586.00	42,179,827.88
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	97,635,923.00	115,326,020.30
210201	Тэтгэврийн даатгал	67,791,709.81	80,119,558.70
210202	Тэтгэмжийн даатгал	7,975,488.01	9,419,071.19
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,266,150.43	7,452,516.81
210204	Ажилгүйдлийн даатгал	1,415,528.41	1,655,607.41
210205	Эрүүл мэндийн даатгал	14,187,046.34	16,679,266.19
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	383,756,169.00	414,568,481.04
210301	Гэрэл, цахилгаан	20,330,696.00	24,975,681.04
210302	Түлш, халаалт	331,840,473.00	368,710,300.00
210303	Цэвэр, бохир ус	31,585,000.00	20,882,500.00
2105	Нормативт зардал	117,658,650.00	136,580,350.00
210502	Хоол, хүнс	117,658,650.00	136,580,350.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,000,000.00	5,000,000.00
210604	Урсгал засвар	3,000,000.00	5,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,489,146.00	10,589,567.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,046,600.00	3,046,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,442,546.00	7,542,967.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	40,792,460.00	39,458,224.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	28,121,760.00	28,233,372.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,670,700.00	11,224,852.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	147,163,915.00	88,302,719.88
2132	Бусад урсгал шилжүүлэг	146,268,200.00	88,291,400.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	71,488,300.00	68,678,800.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	74,779,900.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	19,612,600.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	895,715.00	11,319.88
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	895,715.00	11,319.88
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>100,937,989.00</u>	<u>140,149,146.97</u>



5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	41,386,000.00	44,414,990.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	41,386,000.00	44,414,990.00
2200	Дотоод эх үүсвэрээр	41,386,000.00	44,414,990.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	41,386,000.00	44,414,990.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-41,386,000.00</u>	<u>-44,414,990.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	59,551,989.00	95,734,156.97
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	59,551,989.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	59,551,989.00	155,286,145.97

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,291,187,505.12	560,211,479.27	3,559,007,077.13	5,410,406,061.52
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,291,187,505.12	560,211,479.27	3,559,007,077.13	5,410,406,061.52
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-384,746,653.05	-384,746,653.05
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,291,187,505.12	560,211,479.27	2,806,601,218.55	4,658,000,202.94
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,291,187,505.12	560,211,479.27	2,806,601,218.55	4,658,000,202.94
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,291,187,505.12	560,211,479.27	2,806,601,218.55	4,658,000,202.94
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-237,086,821.12	-237,086,821.12
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,291,187,505.12	560,211,479.27	2,569,514,397.43	4,420,913,381.82



2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Гүйцэтгэл
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,522,793,800.00	1,367,559,691.03	155,234,108.97	89.81
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,522,793,800.00	1,367,559,691.03	155,234,108.97	89.81
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,421,586,000.00	1,279,268,291.03	142,317,708.97	89.99
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,050,099,900.00	934,320,139.73	115,779,760.27	88.97
210101	Үндсэн цалин	716,077,400.00	670,892,150.86	45,185,249.14	93.69
210102	Нэмэгдэл	281,809,600.00	221,248,160.99	60,561,439.01	78.51
210104	Урамшуулал	52,212,900.00	42,179,827.88	10,033,072.12	80.78
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	131,262,500.00	115,326,020.30	15,936,479.70	87.86
210201	Тэтгэврийн даатгал	89,258,500.00	80,119,558.70	9,138,941.30	89.76
210202	Тэтгэмжийн даатгал	10,501,000.00	9,419,071.19	1,081,928.81	89.70
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,400,800.00	7,452,516.81	948,283.19	88.71
210204	Ажилгүйдлийн даатгал	2,100,200.00	1,655,607.41	444,592.59	78.83
210205	Эрүүл мэндийн даатгал	21,002,000.00	16,679,266.19	4,322,733.81	79.42
2105	Нормативт зардал	143,193,300.00	136,580,350.00	6,612,950.00	95.38
210502	Хоол, хүнс	143,193,300.00	136,580,350.00	6,612,950.00	95.38
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,590,400.00	10,589,567.00	833.00	99.99
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,047,100.00	3,046,600.00	500.00	99.98
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,543,300.00	7,542,967.00	333.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	86,439,900.00	82,452,214.00	3,987,686.00	95.39
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	75,124,900.00	71,137,362.00	3,987,538.00	94.69
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,315,000.00	11,314,852.00	148.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	101,207,800.00	88,291,400.00	12,916,400.00	87.24
2132	Бусад урсгал шилжүүлэг	101,207,800.00	88,291,400.00	12,916,400.00	87.24
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	81,595,200.00	68,678,800.00	12,916,400.00	84.17
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	19,612,600.00	19,612,600.00	-	100.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	59,551,989.00	(59,551,989.00)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	155,286,145.97	(155,286,145.97)	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	60	60	-	100.0
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	36	36	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	23	23	-	100.0



3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Эрдэнэ сумын сургууль нь 1926 онд Жанчивлангийн бага сургууль нэртэй анх байгуулагдсан. Сургууль нь 1951 онд долоон жилийн сургууль, 1973 онд 8 жилийн сургууль, 1980 он 8 жилийн сургууль, 2010 онд 11 жилийн сургууль, 2015 онд 12 жилийн сургууль болж өргөжин тэлсэн. 320 хүүхдийн хүчин чадалтай 2 хичээлийн байртай, бага сургуулийн байр 1980 онд ашиглалтад орсон.

2017 онд 320 хүүхдийн хичээлийн байр 2,9 тэрбум төгрөгөөр баригдан ашиглалтад орсон. 2 спорт заалтай, 1 урлаг заалтай, 1,46 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 160 хүүхдийн дотуур байр 2019 онд ашиглалтад орсон, 31 тасагт 180 хүүхэд амьдарч байна.

Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, үнэлгээ, арга зүй, технологи, суралцагчийн эрх, хамгаалал, хөгжил, төлөвшил, тэгш хамран сургалт, ажил мэргэжлийн чиг баримжаа, багш, ажилтны мэргэжлийн тасралтгүй хөгжил, цахим шилжилт, сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд багш, удирдах ажилтныг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, зөвлөн туслах, суралцагч, эцэг, эх, асран хамгаалагч, олон нийтийг энэ чиглэлийн мэдээллээр хангах, дэмжлэг үзүүлж ажиллах, холбогдох талуудын түншлэлийн үйл ажиллагааны хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаар Боловсролын ерөнхий газар болон боловсролын үнэлгээ, эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллагыг мэдээллээр хангах, санал боловсруулах, Хүүхэд бүрийг бие даан суралцах ажиллах чадвартай болгон төлөвшүүлэх “Зөв Монгол” хүнийг хөгжүүлэх олон талт нөхцөл боломжийг бүрдүүлэх, боловсролын үйлчилгээг хүртээмжтэй, чанартай, үр ашигтай байдлаар үзүүлэхэд чиглэж ажиллаж байна.

Эрдэнэ сумын ерөнхий боловсролын сургууль нь бага, суурь, бүрэн дунд боловсрол олгох үйлчилгээг сургалтын хөтөлбөрт нийцүүлэн эрхлэн явуулж байна.

Эрдэнэ сумын ерөнхий ерөнхий боловсролын сургууль нь 35,856 м.квадрат газрыг боловсролын зориулалтаар, Эрдэнэ хайрхан уулын өвөрт 106,069 м.квадрат газрыг хүүхдийн зуслан зориулалтаар, Өлзийтийн ам нэртэй газарт 700 м.квадрат газрыг өвөлжөө хаваржааны зориулалтаар эзэмшдэг байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Эрдэнэ сумын сургууль нь бага, суурь, бүрэн дунд боловсрол олгох үйл ажиллагаа явуулдаг, Боловсрол шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм.

Сургууль нь сургалт, үйл ажиллагааны орчинд суралцагчийн аюулгүй байдлыг хангах, хамгаалах, мэдлэг чадвар авьяасаа хөгжүүлэх, төлөвшихөд дэмжлэг үзүүлэх, хүүхдийн хөгжил, төлөвшил, сурах үйл явцын талаар эцэг эх асран хамгаалагч, дэмжигчтэй хамтран ажиллах чиг үүргийг гүйцэтгэнэ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ✓ Төсвийн тухай хууль
- ✓ Боловсролын ерөнхий хууль шинэчилсэн найруулга
- ✓ Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль
- ✓ Зөвшөөрлийн тухай хууль
- ✓ Багшийн хөгжлийг дэмжих тухай
- ✓ Хөрөнгийн үнэлгээний тухай хууль



- ✓ Засгийн газрын 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 240 дүгээр тогтоолоор Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, түүнд хамрах албан тушаалын жагсаалтад өөрчлөлт орсон.
- ✓ Засгийн газрын 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор цалингийн доод хэмжээг тогтоосон.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Эрдэнэ сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

НББ-ийн бодлогын баримт бичиг нь байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэхэд баримтлах НББ-ийн зарчим, бодлогуудыг тодорхойлох, зайлшгүй мөрдөгдөх санхүүгийн бүртгэл, хяналтын өдөр тутмын үйл ажиллагааны хэм хэмжээг тогтоон, санхүүгийн сахилга батыг мөрдүүлэх, НББ-ийг хөтөлж, санхүүгийн тайлан бэлтгэн хэрэглэгчдийг мэдээллээр хангах үндсэн зориулалтаар ашиглагдана. НББ-ийн бодлогын баримт бичгийн заалт бүрийн агуулга нь төсвийн байгууллагад хамаарна.

Тус байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь үйл ажиллагааны онцлог, холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандарттай нийцсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Эрдэнэ сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 237,086.8 сая төгрөгөөр буюу 11,04 хувиар буурсан байна.



Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	59,551.99	155,286.15	95,734.16
Авлага	3,644.35	142.07	(3,502.28)
Урьдчилгаа			-
Бараа материал	60,395.73	70,581.88	10,186.15
Үндсэн хөрөнгө	4,534,408.14	4,194,903.29	(339,504.85)
Нийт хөрөнгө	4,658,000.20	4,420,913.38	(237,086.82)
Өр төлбөр			-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	4,658,000.20	4,420,913.38	(237,086.82)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	4,658,000.20	4,420,913.38	(237,086.82)

Дээрх хүснэгтээс харахад нөлөө бүхий өөрчлөлт мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Тайлант онд мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 155,286.1 мянган төгрөгөөр харагдаж байгаа нь улсын төсвөөс хүлээн авсан санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдлийг буцаан төвлөрүүлээгүй байна.

Авлагын данс 3,502.2 мянган төгрөгөөр буурсан нь хоёр албан хаагчаас авах авлага барагдаж хасагдсан байна.

Бараа материал 10,186.15 төгрөгөөр өссөн нь аж ахуйн материалын дансанд номын сангийн өрөөг тохижуулсан эд хогшил авсан үнийн дүн, бусад хангамжийн материалын дансанд физикийн кабинетын хичээлийн хэрэглэгдэхүүн хандиваар авсан нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 339,504.85 мянган төгрөгөөр буурсан нь Эрдэнэ сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 21-ны өдрийн 10 дугаар тогтоолоор хуримтлагдсан элэгдэл, үндсэн хөрөнгө акталж данснаас хасалт хийсэн нь нөлөөлсөн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,986,700.2 мянган төгрөг, нийт зарлагыг 1,986,700.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 2023 оны зардлыг 463,906.4 мянган төгрөгөөр бууруулж, 1,522,793.1 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь 2023 оны төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүй эсвэл төсвийн хэмнэлтийн хуулиас шалтгаалсан байна.



3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 463,906.4 мянган төгрөгөөр бууруулж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 12 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,522,793.8 мянган төгрөгийг улсын төсвөөс, 419,579.8 мянган төгрөгийг орон нутгийн сангаас бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,522,793.8 мянган төгрөгийн санхүүжилт олгож төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,367,559.9 мянган төгрөг буюу 90.0 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 155,233.9 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Байр ашиглалтын үйлчилгээ	30,174.00	30,174.00	-	100.00
2	Сургалт семинар	15,087.00	15,087.00	-	100.00
3	Эрүүл мэндийг дэмжих	30,173.00	30,173.00	-	100.00
4	Үдийн цай хөтөлбөр	815,952.00	686,788.00	129,164.00	84.17
5	Дотуур байрны үйлчилгээ	2,147,779.00	1,955,601.00	192,178.00	91.05
6	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	377,085.00	377,085.00	-	100.00
7	Багш ажилчдын сургалт	67,890.00	42,240.00	25,650.00	62.22
8	Бичиг үсгийн боловсрол	8,051.00	161.00	7,890.00	2.00
9	Боловсролын стандарт	9,334,452.00	8,291,546.00	1,042,906.00	88.83
10	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	2,369,317.00	2,227,531.00	141,786.00	94.02
11	Гүнзгийрүүлсэн сургалт	1,507.00	1,506.00	1.00	99.93
12	Сурах бичгийн түрээс	30,471.00	30,466.00	5.00	99.98

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тус байгууллага нь 2023 онд худалдан авах ажиллагаагаар цахим дэлгүүрээс худалдан авалтаар Техно Зон ХХК-тай ТӨАЭСЕБС/011/001 тоот гэрээ байгуулж Таблет /Android 32GB/ худалдан авахаар 31,465.0 мянган төгрөгийг зарцуулсан байна. Үдийн цай хөтөлбөр 686,788.0 мянган төгрөг, дотуур байрны үйлчилгээ 1,955,601.0 мянган төгрөгөөр худалдан авалт хийхдээ Засаг даргын тамгын газраас нэгдсэн журмаар тендер сонгон шалгаруулалт хийдэг, нэгдсэн гэрээтэй байна.



4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Эрдэнэ сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Голден пэйж Аудит ХХК-ийн аудитор Я.Оюун, Шинжээч Х.Ариунжаргал, Ц.Цацрал нар гүйцэтгэж, анхан шатны хяналтыг аудитын менежер, гүйцэтгэх захирал С.Оюунгэрэл хэрэгжүүлж, хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ц.Саранчимэг, аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүрсэн.

Төв аймгийн Эрдэнэ сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Голден пэйж Аудит ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 09/05 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын 6,647,344.1 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 99,710.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 74,782.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага нь бүтэц орон тоог нэмэгдүүлэхгүй байх, үндсэн үйл ажиллагаатай холбоотой нэмэгдэл цалинг 60,561.4 мянган төгрөг, үдийн цай хөтөлбөрийг 129,164.0 мянган төгрөгөөр, дотуур байрны үйлчилгээг 192,178.0 мянган төгрөгөөр хэмнэн ажилласан. Хэмнэлтийн хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, байгаа хэдий ч байгаль цаг уурын өөрчлөлт, цас зудын эрсдэлтэй үед хэмнэлтийн хуулийн хэрэгжилт хангагдахгүй байх талтай.



4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

4.4.1.1 Тайлант хугацаанд шилэн дансанд нийт мэдээлэх 159 мэдээллээс 153 мэдээллийг хугацаанд нь байршуулж, хугацаа хоцорсон 1 мэдээлэл, 5 мэдээлэл байршуулаагүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.4-д "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" заалттай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансанд мэдээллийг хугацаанд нь үнэн зөв мэдээлдэг байх зөвлөмж хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

4.4.2.1 Улсын бүртгэлийн гэрчилгээнд хөрөнгийн хэмжээ 1,674,085.0 мянган төгрөг, санхүү байдлын тайлан дээр Засгийн газрын оруулсан капитал 1,291,187.5 мянган төгрөг буюу Засгийн газрын оролцоо сан 382,897.5 мянган төгрөгөөр зөрүүтэй байгаа нь санхүүгийн тайланд тусгагдсан ажил гүйлгээ буюу үйл явдал, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Мэдээллийг үнэн зөв баталгаажуулах, бүртгэлдээ өөрчлөлтийг оруулдаг байх зөвлөмж хүргүүлэв.

4.4.2.2 Эрдэнэ сумын ерөнхий боловсролын сургуулийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 3 давхар дотуур байрны барилга, аж ахуйн, гүн өрмийн худаг, уурын зуухны байр гэсэн хөрөнгө нь Мэргэжил боловсролын сургуулийн эзэмшил газарт баригдсан, 3 давхар дотуур байрны чиглэлээр ашиглан засвар үйлчилгээ ашиглалтын төлбөрийг төлж байна. Энэ нь санхүүгийн тайлангийн дуусгавар болсон өдөр хөрөнгө /авлага/, өр төлбөр тухайн аж ахуйн нэгж, байгууллагад бодитой оршин байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.



Шийдвэрлэсэн нь: Төрийн өмчийн хорооны 2013 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн 13 тоот хуралдааны тэмдэглэлийг үндэслэн, хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэх зөвлөмж өгөв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар анхан шатны и-баримтын бүрдэл, Засгийн газар оролцоо сангийн бүртгэл, цалинтай холбоотой бүртгэл, шилэн дансны мэдээлэл, бичиг хэрэг хөтлөлт, өглөгийн данстай холбоотой нийт 7 зөвлөмж хүргүүлснээс 3 зөвлөмж хэрэгжүүлэн ажилласан, 4 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 67,375.0 мянган төгрөгийн 3 зөрчил илэрснээс 67,375.0 мянган төгрөгийн 2 зөвлөмжийг 74,6 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	3	67,735.0	2	50,552.3	74.6
Нийт дүн	3	67,375.0	2	50,552.3	74.6

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитын явцад дараагийн аудитаар анхаарах асуудал төсөв, санхүүжилтийг үндэслэлтэй баталдаг байх, шинэчлэлийн бодлого, төрийн чиг үүргийг хангалттай хэрэгжүүлэн ажиллаж байгаа талаар анхаарал хандуулах болно. Сургуулийн үндсэн хөрөнгө болон газар эзэмших эрхтэй холбоотой асуудлыг хянаж үзэх, газрын ашиглалт, баталгаажуулалт, сайжруулалт, төлбөр төлөлтийн талаар дараагийн аудитаар авч үзнэ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 46,315.5 мянган төгрөгийн 3 зөрчил илэрснээс, 46,096.6 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлага, дахин давтахгүй байх 1 зөвлөмж хүргүүлээ.

5.2 Албан шаардлага

1. Мөнгөн хөрөнгийн түүврээр үйл ажиллагааны зарцуулалт гаргах, бараа түүхий эд, материал худалдан авахдаа анхан шатны цахим баримт 5,709.2 мянган төгрөгөөр дутуу бүртгэсэн байгаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 6.5-д Төлбөрийн баримт "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо



хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ.” заалтуудыг хэрэгжүүлж ажиллах гэсэнтэй нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь. МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.1-д “нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй”; 4.2.1.11-д “Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

2. Мөнгөн хөрөнгийн түүврийн горим сорил хэрэгжүүлэхэд үйл ажиллагааны зарцуулалт гаргах, бараа түүхий эд, материал худалдан авахдаа анхан шатны цахим баримт 40,387.3 мянган төгрөгөөр илүү бүртгэсэн, гэрээгүй баримтжуулаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “ холбогдох олон улсын стандарт , эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянан, баталгаажуулах” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн оршин байх, тохиолдсон байх, үнэлгээ, иж бүрэн байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдтэй нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь. МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.1-д “нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй”; 4.2.1.11-д “Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Өглөгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Татварын цахим тайлангийн системээр газрын төлбөр 218.9 мянган төгрөгийн татвар төлөөгүй өглөгтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Газарын төлбөрийг хуулийн хугацаанд төлж барагдуулдаг байх,



Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Цахим баримт 5,709.2 мянган төгрөгөөр дутуу бүртгэсэн	1	5,709.2			1	5,709.2						
Цахим баримт 40,387.3 мянган төгрөгөөр илүү бүртгэсэн, баримтжуулаагүй	1	40,387.3			1	40,387.3						
Газрын төлбөр 218.9 мянган төгрөгийн татвар төлөөгүй өглөгтэй	1	218.9					1	218.9				
Дүн	3	46,315.4			2	46,096.5	1	218.9				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Хугацаа хоцорсон 1 мэдээлэл, 5 мэдээлэл байршуулаагүй	1						1	
Дүн	1						1	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Засгийн газрын оролцоо сан 382,897.5 мянган төгрөгөөр зөрүүтэй	1	382,897.5					1	382,897.5
Дүн	1	382,897.5					1	382,897.5
Нийт дүн	2	382,897.5					2	382,897.5



ТӨВ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 12 өдөр

Дугаар 17 НБ/0516-ТӨА 2024/

Зуунмод

256/НА-СТА-ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэ сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар анхан шатны цахим баримтгүй 5,709,200 /таван сая долоон зуун есөн мянга хоёр зуун/ төгрөгөөр дутуу хөтөлж баримтжуулаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 6.5-д Төлбөрийн баримт "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 "Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага"-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ." заалтуудыг хэрэгжүүлж ажиллах гэсэнтэй нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль, тогтоомж, гэрээ хэлэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Цахим төлбөрийн баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээ хийсэн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт¹ ирүүлэх;

¹Төв аймаг, Зуунмод сум, 6 дугаар байр, Төр захиргааны 2 дугаар байр 105 тоот Утас: 70272582

019040082



2. Цаашид алдаа², зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэ сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал Л.Хосбаяр, нягтлан бодогч А.Эрболат нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



/Ц.ХИШИГЖАРГАЛ/

ГОЛДЕН ПЭЙЖ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

/С.ОЮУНГЭРЭЛ/

²Төв аймаг, Зуунмод сум, 6 дугаар байр, Төр захиргааны 2 дугаар байр 105 тоот Утас: 70272582



ТӨВ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 12 өдөр

Дугаар 18-14510516-ТӨА-2024/250/НА-ТА-7113 Зуунмод

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэ сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар үйл ажиллагааны зарцуулалт гаргах, бараа түүхий эд, материал худалдан авахдаа анхан шатны цахим баримт 40,387,300 /дөчин сая гурван зуун наян долоон мянга гурван зуун/ төгрөгөөр илүү бүртгэсэн зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянан, баталгаажуулах” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн оршин байх, тохиолдсон байх, үнэлгээ, иж бүрэн байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдтэй нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11-д “хууль, тогтоомж, гэрээ хэлэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Цахим төлбөрийн баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээ хийсэн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт³ ирүүлэх;

³Төв аймаг, Зуунмод сум, 6 дугаар байр, Төр захиргааны 2 дугаар байр 105 тоот Утас: 70272582

019040086



2. Цаашид алдаа⁴, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэ сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал Л.Хосбаяр, нягтлан бодогч А.Эрболат нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



[Signature]
/Ц.ХИШИГЖАРГАЛ/

ГОЛДЕН ПЭЙЖ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

[Signature]
/С.ОЮУНГЭРЭЛ/

⁴Төв аймаг, Зуунмод сум, 6 дугаар байр, Төр захиргааны 2 дугаар байр 105 тоот Утас: 70272582